



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/225/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn	Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Архангай аймаг 2022 он	Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК Утас: 99099119 Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	6
,	6
3. Аудитын тайлан.....	6
3.1 Ерөнхий зүйл.....	6
3.2 Дотоод хяналт.....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Материаллаг байдал	7
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	8
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	8
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	9
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	9
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	10
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	10
8. Аудитын илрүүлэлт	10
8.1 Албан шаардлага	10
8.2 Зөвлөмж	11
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ИТХ	Иргэдийн төлөөлөлчдийн хурал

1.Аудитын санал дүгнэлт



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

“АРХАНГАЙД ҮЙЛДВЭРЛЭВ”
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ц.ЛУВААНЖАЛБУУ ТАНАА

2022.09.15 № 156
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн дүнг эс тооцвол “Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд түрээслэгч нартай гэрээ байгуулахдаа төлбөрийн дүнд НӨАТ-ыг оруулж баталгаажуулаагүйгээс НӨАТ-ын тооцоог 7.2 сая төгрөгөөр алдаатай бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ”, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг “Татвар төлөгч холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлнө”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг “албан татварыг дор дурдсан журмаар ногдуулна”, 8.1.1 “бараа, ажил, үйлчилгээг ... борлуулсан бол тухай бүрд” гэж заасныг тус тус зөрчсөн, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Аж ахуйн

нэгжийн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-тай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	6,078,996.44	19,157,908.69
1.1.2	Дансны авлага	5,445,985.00	5,805,330.00
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	1,034,495.00	1,104,495.00
1.1.6	Бараа материал	5,855,893.83	10,180,340.01
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	18,415,370.27	36,248,073.69
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,174,702,095.76	3,116,299,322.76
1.2.2	Биет бус хөрөнгө	12,084,000.00	12,084,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,186,786,095.76	3,128,383,322.76
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,205,201,466.03	3,164,631,396.46
2.1.1.1	Дансны өглөг	3,166,515.86	0.00
2.1.1.2	Цалингийн өглөг	186,998.33	0.00
2.1.1.3	Татварын өр	19,891,433.26	10,357,424.79
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	23,670,290.00	25,058,890.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	46,915,237.45	35,416,314.79
2.2	Өр төлбөрийн нийт дүн	46,915,237.45	35,416,314.79
2.3.1	Өмч: - төрийн	3,154,084,200.00	3,154,084,200.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	4,202,028.58	(24,869,118.34)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	3,158,286,228.58	3,129,215,081.67
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	3,205,201,466.03	3,164,631,396.46

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

			/төгрөгөөр/
Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	Борлуулалтын орлого (цэвэр)	0.00	153,852,163.93
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	0.00	0.00
3	Нийт ашиг (алдагдал)	155,765,433.75	153,852,163.93
1	Түрээсийн орлого	127,736,853.75	153,852,163.93
5	Хүүний орлого	0.00	2,837,060.00
8	Бусад орлого	51,923,200.00	40,562,429.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	227,410,711.69	227,238,405.02
11	Санхүүгийн зардал	112,400.00	111,800.00
12	Бусад зардал	3,283,200.00	861,037.49
1	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(23,117,677.94)	(30,959,589.58)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	0.00	(30,959,589.58)
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(23,117,677.94)	(30,959,589.58)
1	Орлогын нийт дүн	(23,117,677.94)	(30,959,589.58)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/			
ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2020 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	3,154,084,200.00	0.00	3,154,084,200.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	4,202,028.58	4,202,028.58
2021 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	3,154,084,200.00	4,202,028.58	3,158,286,228.58
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	1,888,442.66	1,888,442.66
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	(30,959,589.58)	(30,959,589.58)
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00	0.00
2021 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	3,154,084,200.00	(24,869,118.34)	3,129,215,081.67

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	174,024,150.00	199,196,494.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	171,259,530.00	155,908,965.00
	Бусад мөнгөн орлого	2,764,620.00	43,287,529.00
1.2	Мөнгөн зарлага (-)	159,355,537.56	191,438,506.75
	Ажиллагчдад төлсөн	58,368,053.00	60,295,242.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	16,570,707.72	17,868,435.17
	Бараа материал худалдан авахад төлсөн	31,804,066.00	32,267,375.00
	Ашиглалтын зардалд төлсөн	30,547,647.09	39,030,721.68
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,394,763.00	1,092,570.00
	Татварын байгууллагад төлсөн	6,476,803.97	37,589,955.41
	Бусад мөнгөн зарлага	11,193,496.78	3,294,207.49
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	7,757,987.25
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	7,579,725.00
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	2,743,325.00
	Бусад (Түрээсийн барьцаа)	0.00	4,836,400.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	2,258,800.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	1,958,900.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	904,000.00	299,900.00
	Хөрөнгө оруулалт эзэмшихэд төлсөн	14,291,230.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	5,320,925.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(526,617.56)	13,078,912.25
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,605,614.00	6,078,996.44
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,078,996.44	19,157,908.69

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/Д	Үзүүлэлт	х.нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт орлого	мян.төг	180,662.6	192,064.5	197,251.5	5,187.0	102.7
2	а/ Түрээсийн орлого	мян.төг	128,739.4	162,416.4	153,852.1	(8,564.3)	94.7
3	б/ Бусад орлого	мян.төг	51,923.2	29,648.1	43,399.4	13,751.3	146.4
4	Нийт зардал	мян.төг	162,609.5	191,615.9	228,211.3	36,595.4	119.1
5	Үүнээс; Удирдлагын зардал	мян.төг	162,609.5	191,615.6	227,238.4	35,622.8	118.6
6	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	(23,117.6)	448.9	(30,959.6)	(31,408.5)	(6,896.8)
9	а/Орлогын татварт	мян.төг			70.0	70.0	
10	б/НӨТ	мян.төг	4,131.6		7,426.5	7,426.5	
11	в/НДШ	мян.төг	8,626.0		9,005.5	9,005.5	
12	г/Хүн амын орлогын албан татвар	мян.төг	3,500.4		3,449.2	3,449.2	
13	д/Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян.төг		18,000.0	28,386.7	10,386.7	157.7
14	ж/Бусад татвар	мян.төг		1,473.2		(1,473.2)	0.0
16	Нийт ажиллагсдын тоо	хүн	11.0	11.0	11.0	0.0	100.0
17	Нийт цалингийн сан	мян.төг	70,208.5	90,661.8	81,666.7	(8,995.1)	90.1
18	Хөрөнгө оруулалт	мян.төг	15,921.0	0.0	2,258.8	2,258.8	-
19	Нийт авлага	мян.төг	6,480.4		6,909.8	6,909.8	-
21	Нийт өглөг	мян.төг	46,915.2		35,416.3	35,416.3	-

,

3. Аудитын тайлан.

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, шилэн дансны хууль, албан шаардлага, зөвлөмжийг тусгасан болно

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Гэрэлт хөхийн тэнцвэр Аудит ХХК-ийн аудитор Л.Амарзаяа гүйцэтгэж, чанарын хяналтыг менежер Ж.Ням-Осор, захирал Д.Баатарсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

“Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайланг Архангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 145 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Тус байгууллага нь Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.2, 8.2.1 дэх заалт, Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 9-ны өдрийн 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт зохион байгуулах нийтлэг журмын дагуу дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд компанийн удирдлагаас дотоод хяналт хэрэгжүүлээгүй учир төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн болно.

Тус компани нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

Байгууллага нь дотоод аудитын орон тоо, хэлтэс, тасаг байхгүй учир дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авах дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшин 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 156.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ-ын зорилго нь худалдаа эрхлэгчдэд тав тухтай, хамгийн бага үнэтэй түрээсийн үйлчилгээг санал болгох” юм. Тус байгууллагын дүрмэнд үйл ажиллагааны чиглэлийг Худалдаа үйлчилгээний төв гэж тодорхойлжээ. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар статустай байна. Өмчийн 100 хувийг орон нутаг эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ нь аймгийн ИТХТ-ийн 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 43 дугаар тогтоолоор байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дүгээр зүйлийн Орон нутгийн өмчийн талаархи иргэдийн Төлөөлөгчдийн хурлын бүрэн эрх, 77.1.4 “орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

“Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ -ыг Эрдэнэбулган сумын ИТХ-ын 2020 оны 10 сарын 29-ны өдрийн тогтоолоор өмчлөх эрхийг шилжүүлж авсан байна. Энэ хүрээнд Эрдэнэбулган сумын ИТХ нь үйл ажиллагааг хянан удирдлагаар хангаж байгаа учир Төлөөлөн удирдах зөвлөлгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна. Энэ хүрээнд аймгийн худалдааны төвийн үйл ажиллагааг цаг үеийн менежментийн арга зарчимд нийцүүлэн зүгшрүүлэх, аймгийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгох, нэг цэгээс борлуулж, сурталчлах арга хэмжээ авсан байна.

Тус байгууллага нь “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй буюу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөөгүй, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог бууруулаагүй, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоож ажиллаагүй байна. Мөн орон нутгаас төсөв, санхүүгийн дэмжлэггүй зөвхөн өөрийн орлогоор үйл ажиллагааныхаа зардлыг санхүүжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,078.9	19,157.9	13,079.0
Авлага	6,480.3	6,909.8	429.5
Бараа материал	5,855.8	10,180.3	4,324.5
Үндсэн хөрөнгө	3,174,703.1	3,116,299.3	(58,403.8)

Биет бус хөрөнгө	12,084.0	12,084.0	0.0
Нийт хөрөнгийн дүн	3,205,202.1	3,164,631.4	(40,570.7)
Өр төлбөрийн дүн	46,915.2	35,416.3	(11,498.9)
Эздийн өмч	3,158,286.9	3,129,215.1	47,759.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,205,202.1	3,164,631.4	(40,570.7)

Банк дахь харилцах дансны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 19.2 сая төгрөг байна.

Шалгагдагч байгууллага нь төлбөрийн чадваргүй болсон Чингис хаан , Үндэсний хөрөнгө оруулалтын банкинд мөнгөн хөрөнгө байршуулаагүй.

Авлагын дансны үлдэгдэл 6.9 сая төгрөг байгаа нь ААНОАТ-ын урьдчилж төлсөн зардал 1.1 сая төгрөг, Хувь хүмүүсээс авах 5.8 сая төгрөгийн түрээсийн авлагын үлдэгдэл байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 10.2 сая төгрөг болж 4.3 сая төгрөгөөр өссөн нь нүүрс, аж ахуйн материалын нөөц нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 58.4 сая төгрөг болж буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 35.4 сая төгрөг байгаа нь урьдчилж орсон орлого 25.1 сая төгрөг, болон албан татварын төлөгдөөгүй зардал 10.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаатай холбоотой.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ нь Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 25 тушаалаар 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 192.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 191.6 сая төгрөгөөр, 0.4 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоожээ. Гүйцэтгэлээр 197.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 5.2 сая төгрөг буюу 2.7 хувиар давуулж биелүүлсэн бол нийт зардлын гүйцэтгэл 228.2 сая төгрөг болж төлөвлөснөөс 36.5 сая төгрөг буюу 19.1 хувиар хэтрүүлсэн байна. Зардлын хэтрэлт нь зорилтот түвшний төлөвлөгөөг батлуулахдаа үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг төлөвлөгөөнд тусгаагүйтэй холбоотой байна.

Тайлант онд 0.4 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн боловч 31.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Төлөвлөсөн ашиг 31.4 сая төгрөгөөр буурсан нь төлөвлөгөөнд элэгдлийн зардлыг тусгаагүйтэй холбоотой байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна. Энэ хүрээнд Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 61 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь тайлант онд нийт 146 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 28 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 118 мэдээллийг хугацаа хоцроож байршуулжээ. Энэ нь 2020 онд шилэн дансанд бүртгэлгүй байсан ба шинээр бүртгүүлж өмнөх оны мэдээллийг нөхөж оруулсантай холбоотой байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 27.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 4.1 сая төгрөгийн 3 алдаа зөрчилд албан албан шаардлага, 23.8 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгч хэрэгжилтийг 100 хувь хангуулсан байна

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	0	0					
Албан шаардлага	3	4077,9	3	4077,9	0	0	100%
Зөвлөмж	2	23709,4	2	23709,4	0	0	100%
Нийт дүн	5	27,787.3	5	27,787.3			100%

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын бизнес төлөвлөгөөний хэрэгжилт, орлого, зардлын гүйцэтгэл, татварын хууль тогтоомжуудын хэрэгжилтийг шалгах

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 7.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 0.3 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүллээ.

Залруулагдаагүй 7.5 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон 1.6 сая төгрөгийн материаллаг түвшнээс их байгаа тул хязгаарлалттай санал дүгнэлт өглөө.

8.1 АЛБАН ШААРДЛАГА

Илрүүлэлт:

Түрээслэгч нартай байгуулсан гэрээний түрээсийн төлбөрийн дүнд 7.2 сая төгрөгийн НӨАТ-ыг оруулж тооцоогүй, НӨАТ-ын тооцоо үүсгэхдээ орлого дансанд бууруулах бичилт хийж бүртгэж алдаатай тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ”, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “Татвар төлөгч холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлнө”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1. албан татварыг дор дурдсан журмаар ногдуулна, 8.1.1 “бараа, ажил, үйлчилгээг ... борлуулсан бол тухай бүрд” заалтыг зөрчсөн, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөрчлийг таслан зогсоож, НӨАТ-ыг тооцон оруулсан дүнгээр түрээсийн төлбөрийг тогтоож гэрээг шинэчлэн байгуулах, НӨАТ-ын тайланг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд бүртгэж тайлагнаж хэвших

8.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Түрээслэгчийн барьцааны хөрөнгөнөөс 0.25 сая төгрөгийн түрээсийн төлбөрийг суутгахдаа алдаатай бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйл “Нягтлан бодох бүртгэл хөтлөх” Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ыг хэрэгжүүлээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийг хууль, заавар, журмын дагуу хөтөлж байх

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллага нь 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг нарийн тооцоо судалгаагүй, алдагдалтай байхаар тооцсон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь заалтыг хэрэгжүүлээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ашигт ажиллагааг нэмэгдүүлэх бодит тооцоо судалгаанд үндэслэн батлуулж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/														
№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	Архангайд үйлдвэрлэв ОНӨААТҮГ	APA-2022/225/HA-CTA-ONA	Түрээслэгч нартай хийсэн гэрээний төлбөрийн үнийн дүнд НӨАТ оруулж тооцоогүй мөн үүнтэй холбоотойгоор НӨАТ-ын тооцоо үүсгэхдээ орлого дансны ДТ-д бүртгэж алдаатай тайлагнасан байна.	Төлбөрийн дүнд НӨАТ-ыг оруулж тооцон гэрээг шинэчлэхх, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах албан шаардлага өгсөн.	1	7,163.9					1	7,163.9		
2	Архангайд үйлдвэрлэв ОНӨААТҮГ	APA-2022/225/HA-CTA-ONA	Түрээсийн барьцаанаас суутгаж түрээсийн орлого зөвшөөрч бүртгэхдээ алдаатай бүртгэсэн	Дансанд зөв бүртгэх зөвлөмж өгсөн	1	256.7							1	256.7
3	Архангайд үйлдвэрлэв ОНӨААТҮГ	APA-2022/225/HA-CTA-ONA	Тус байгууллага нь 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг нарийн тооцоо судалгаагүй, алдагдалтай байхаар баталсан	эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн гаргаж ажиллах зөвлөмж өгсөн	1	0							1	0
	ДҮН				3	7,420.6	-	-	-	-	1	7,163.9	2	256.7
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал														

1	Архангайд үйлдвэрлэв ОНӨААТҮГ	АРА- 2022/225/НА- СТА-ОНА	Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудаст байршуулах 146 мэдээлэл оруулахаас 118 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь өмнөх 2020 онд шилэн дансны бүртгэлгүй байснаас шинээр бүртгүүлж өмнөх оны мэдээлэл нөхөж оруулсантай холбоотой	Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэх	1						1			
	ДҮН				1						1			
	НИЙТ ДҮН				4	7,420.6	-	-	-	-	2	7,163.9	2	256.7